



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарын гол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/104/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: Munguntsetseg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРСИЙН АУДИТЫН ГАЗАР**

41218 Дархан сум аймаг
Дархан сум, 14-д баг
Утас: 7527-3088, Факс: 0170-7527-3088
E-mail: darhanuaa@audit.gov.mn

2022.12.17 № 11
Төрийн Аудитын Газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд эохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв болгөж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй болтлоход шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүтдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх бөгөөд бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгслэлчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТАЛБАН ҮЙРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР



009070075

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1.3	1.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		
	Нийт хөрөнгийн дүн	1.3	1.0
	Нийт өр төлбөрийн дүн	1.3	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1.3	1.0
	Үйл ажиллагааны орлогын дүн	330.5	595.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	330.5	594.3
	Үйл ажиллагааны үр дүн		1.0
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн		1.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
	Тайлант оны үр дүн		1.0
	Эцсийн үлдэгдэл		1.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	330.5	596.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		
	Үйл ажиллагааны ЦМГ	330.5	596.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(330.5)	(595.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		1.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	608.1	595.7
	Урсгал зардал		
	Хөрөнгийн зардал	608.1	595.7
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	604.1	596.7
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4.0	

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шарын гол сумын ОНХС нь Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийн аюулгүй амьдрах орчныг сайжруулах, эрүүл идэвхтэй амьдралыг дэмжих, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, соёл урлаг, боловсролын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, авто замыг засварлан шинэчлэх, хатуу хучилттай авто зам шинээр барих, тохилог орчин эко хорооллыг бий болгох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлдэг байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Шарын гол сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээг 6, 7 дугаар сард, 5 сая төгрөгөөс дээш 14,700.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг тус тус хоцроож, жилийн төсөвт орсон өөрчлөлтийн 1 мэдээлэл, 13,122.0 мянган төгрөгийн 2 худалдан авалтыг мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн байршууллаа.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,238.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 24,538.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 14,700.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй болно.

Зөвлөмж

3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
НИИТ		4	39.2	2	24.5				2	14.7